



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар Б/39

Чингис хот

Ж.Ганбаярыг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Ж.Ганбаярыг 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ж.Ганбаярт Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Ганбаярт үүрэг болгосугай.

4. Ж.Ганбаярт томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2020 оны Б/49 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030229